

## ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ ТООРМОСНЫ ИВҮҮР, ГАР ТООРМОСООР БЭХЛЭХ НОРМ

1.Өртөөний зам дээр вагоныг бэхлэхдээ энэхүү журмын 13.12-13.15-д заасан шаардлагатай тооцоот хамгийн бага нормыг удирдлага болгоно.

2.Хэвгийтэй зам дээр ачаатай бүлэг вагоныг бэхлэх тооцоог гаргахдаа дараах томъёог ашиглан гаргана.

$N$  -голын тоо

$i$  -хэвгий

2 -тогтмол тоо

200 -тогтмол тоо

3.Хэвгийн тоон дээр тогтмол 2 гэсэн тоог нэмж нийлбэрийг гарган тухайн зам дээр бэхлэгдэх вагоны голын тоогоор үржүүлж 200 гэсэн тогтмол тоонд хувааж гарна.

Жишээлбэл нь: 25 ачаатай вагоныг 1,5 мянганы хэвгийтэй зам дээр 2 ивүүрээр бэхлэнэ.

$N = 100$

$i = 1.5$

4.Хэвгийтэй зам дээр хоосон бүлэг вагоныг бэхлэх тооцоог гаргахдаа дараах томъёог ашиглан гаргана.

$N =$  голын тоо

$i =$  хэвгий

3 = тогтмол тоо

200тогтмол тоо

5.Хэвгийн тоон дээр 3 гэсэн тогтмол тоог нэмж нийлбэрийг гарган бэхлэгдэх вагоны голын тоогоор үржүүлж 200 гэсэн тогтмол тоонд хувааж гаргана.

Жишээлбэл нь: хоосон 25 вагоныг 1,5 мянганы хэвгийтэй зам дээр 3 ивүүрээр бэхлэнэ.

$N = 100$

$i = 1,5$

6.Ачаатай бүлэг вагон эсвэл ачаатай ба хоосон вагоноос бүрдсэн бүлэг вагоныг бэхлэхдээ гол тутамд 10 тонноос багагүй даралттай ачаатай вагоны дор тоормосны ивүүр тавина. Хоосон вагон буюу хөнгөн ачаатай / автомашин хоосон чингэлэг гэх мэт/ вагоны дор тоормосны ивүүрийг ивэхдээ бүлэг хоосон вагоны нормоор ивүүрийн тоог бодож гаргана.

7.Тоормосны ивүүрийг вагоны тэргэнцэр тус бүрийн дор тавьж болно. Ивүүрийн хошуу нь хос дугуйн дор бүрэн дарагдсан байна. Тоормосны ивүүрийг тогтмол хэрэглэдэг газарт элстэй хайрцаг тавьж, элсийг мөс, хяруутай үед хэрэглэнэ.

8.Ивүүрийг тэгш зам дээр бүрэлдэхүүний хоёр талаас бэхлэнэ. Хэвгийтэй бол хэвгийтэй талаас нь тооцоот ивүүрээр ивнэ.

9. Өнхөрч болзошгүй талаас бэхэлж байгаа бүлэг вагоны захынх нь биш вагоны дор тоормосны ивүүрээр бэхэлсэн бол энэ вагонтой энэ бүлгийн бусад бүх вагон нь найдвартай холбогдсон эсэхийг дахин шалгасан байна.

10. Вагонууд өнхөрч болзошгүй хүчтэй салхины /15 м/сек хүртэл/ чиглэл тохирсон үед тооцоот ивүүрийг нэгээр, бүр хүчтэй салхитай /15 м/секундээс дээш/ үед хоёроор нэмэгдүүлж бэхлэнэ.

11. Өртөөний зам дээр вагоныг бэхлэхдээ хоосон бүлэг вагоныг бэхлэхэд хэрэглэдэг тоормосны нэг ивүүрийг гар тоормосны 2 голоор орлуулж болох бөгөөд ачаатай бүлэг вагоныг бэхлэхэд хэрэглэдэг нэг ивүүрийг гар тоормосны 3 голоор орлуулж болох тооцоог ашиглаж болно.

--- о О о ---